



ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 6 сарын 2 өдөр

Дугаар #100

Чингис хот

Устгал хийх тухай

Нягтлан бодох бүртгэлийн тухай Монгол улсын хуулийн 11 дүгээр зүйлийн 2.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31.1 дэх заалт, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2015 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 99 дүгээр тушаалаар батлагдсан “Байгууллагын даргын тушаал гаргах /код 136/ журам”-ын 136.4.2-ын “в” заалт, 136.5.2-ын “г” заалт, Цагдаагийн газрын даргын зөвлөлийн 2017 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит бус 09 дүгээр хурлын шийдвэрийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Цагдаагийн газрын 2016 оны жилийн эцсийн тооллого хийсэн ажлын хэсгийн санал оруулсан цаашид ашиглах боломжгүй, чанар байдал нь муудсан 23 нэр төрлийн 5048120 төгрөг /Таван сая дөчин найман мянга нэг зуун хорин/-ний аж ахуйн материалыг зохих журмын дагуу баримтжуулан устгал хийхийг байгууллагын өмч хамгаалах зөвлөл, аж ахуйн ажилтан, цагдаагийн ахлах дэслэгч А.Батхуяг нарт даалгасугай.

2. Устгал хийгдэх аж ахуйн материал, бусад хангамжийн материал, тусгай хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, бичиг хэргийн материалыг хавсралтаар тус тус баталсугай.

3. Устгал хийгдсэн аж ахуйн материал, бусад хангамжийн материал, тусгай хэрэгсэл, сэлбэг хэрэгсэл, бичиг хэргийн материалыг данснаас хасалт хийхийг ахлах нягтлан бодогч, цагдаагийн хошууч Ж.Баатарт зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөвлөлт, зохион байгуулалтын тасгийн дарга, цагдаагийн хошууч Т.Чинбаатарт даалгасугай.

5. Тушаалыг нийт бүрэлдэхүүнд танилцуул.

ДАРГА,
ЦАГДААГИЙН ХУРАНДАА

О.ГАНБАТ